

**СУРАЛЦАГЧ, БАГШ, АЖИЛТНЫГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, ОНОШИЛГООНД
ХАМРУУЛЛАА.**

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалын 1-р хавсралт “Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах журам”-д заасны дагуу аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн багш, дотуур байрын багш, тогооч, туслах тогооч, хүнсний нярав, тогооч нарыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах хуваарь, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/238, А/340 дүгээр тушаалын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношлогооны хуваарийг БОЭТ, ЭМГ-тай хамтран гаргаж, үзлэг, шинжилгээнд хамрууллаа.

Тус үзлэг, шинжилгээнд аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн багш, дотуур байрын багш, тогооч, туслах тогооч, хүнсний нярав, тогооч нийт 920 албан хаагч урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдав.



Хуваарь хургуулэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалын 1-р хэсрэлт "Хугацаага, үйлчилгээний байгууллагын ажилтны эрүүл мэндийн үрشدийн сэрүлгээх үзлэгт хамруулах журам"-д заасны дагуу аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн багш, дотуур байрын багш, хүнсний нэрвэ, тогоч нар үрشدийн сэрүлгээх үзлэг, шинжилгээнд хамруулах хуваарийг хүсрүлгээ байр.

Мөн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/259 дүгээр тушаалын дагуу "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар" батлагдсантай холбогдуулан тус үзлэг, оношилгоог зохион байгуулахтай холбоотой зохицуулалтыг хийж хамтран ажиллана үү.

Хавсралт: 4 хуудастай.



210252135

[illegible]

БГ-аас БОЭТ-д хүргүүлсэн албан захидал
/Зураг№-1/

А/145 үзлэгт хамруулах хуваарь
/Зүраг№-2/

Аймгийн Засаг даргын 2025 оны А/40 захирамжаар “Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүүхдийн шүдний өвчлөлийн тархалтыг бууруулах, хүүхэд эцэг эх, асран хамгаалагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, зөв дадалд сургах, амны хөндийн эмгэг, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээнийг аймгийн Эрүүл мэндийн газар, Монголын шүдний ерөнхий эмч нарын Талст холбоотой хамтран зохион байгуулж байгаа ба бэлтгэл ажлын хүрээнд Хэрлэн сумын ерөнхий боловсролын 11 сургуулийн 6-8 дугаар ангийн нийт 4027 суралцагчид амны хөндийн эмгэг илрүүлэх, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг хийлээ.



**“ШҮД УГААЛТЫН АВАРГА” ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

2025 оны 09 сарын 18 ны өдөр

Чойбалсан хот

Үндэслэл: ДЭМБ-аас 2000 онд шүд цоорох өвчнийг олон шалтгаант халдварт өвчний ангилалд оруулсан. “Амны хөндийн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн хэмжээнд хийсэн судалгаанаас үзэхэд сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн дунд шүд цоорох өвчний тархалт 2011 оны байдлаар 65-96 хувьтай байжээ. Өнөөдөр ч энэ тоо буураагүй болох нь 2018 онд 1190 хүүхдийн дунд явуулсан судалгаанаас харагдаж байна. Тус судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн дунд шүд цоорох өвчний тархалт 86.2 хувьтай, шүд цоорох өвчний эрчим 6.2 цла/ш буюу ДЭМБ-ын байгууллагын шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд өндөр түвшинд байна.

Урьдчилан сэргийлэх арга илрүүлэх үзлэг, оношилгоонд улсын хэмжээнд 2022 оны тавдугаар сарын 1-нээс иргэн бүрийг хамруулж эхэлсэн бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 1 544 968 хүн хамрагджээ. Үзлэгт хамрагдсан нийт хүний 47.6 хувь нь 0-17 насны хүүхэд байгаа бол хүүхдийн өвчлөлийн 253,534 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн тохиолдлоос шүд цоорох 197,080 буюу 77.7%, шүдний гажиг 7313 буюу 2.9% хараа муудах 3013 буюу 1.2 хувийг эзэлж байна. Бүртгэгдсэн шүд цоорох өвчний 162,802 тохиолдол буюу 82.6 хувийг 6-17 насны хүүхэд эзэлж байна. Шүд цоорох өвчний тархалт дэлхийн улс орнуудын дундаж 40-45 хувь байхад Монгол Улсын дундаж 60-99 хувьтай буюу хоёр дахин их байна.

Хүүхдийн шүдний өвчлөлийн тархалтыг бууруулахын тулд хүүхдийн байгууллага, орон нутгийн удирдлага, салбар хоорондын хамтын ажиллагааг тасралтгүй сайжруулж, хүүхэд эцэг эхчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амны хөндийн өвчлөлөөс сэргийлэх арга хэмжээг тогтмол үр дүнтэй хэрэгжүүлэх нь шүд цоорох өвчнөөс сэргийлэх үр дүнтэй боломж юм.

Зорилго: Дорнод аймгийн 2025 оны “Хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний 2.2.1.7 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны А/40 дүгээр захирамжийн хүрээнд “Эрүүл шүд” төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Дорнод аймгийн ЕБС-уудын сурагч, хүүхдүүдийн шүд, амны хөндийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, шүд угаах зөв аргачлалыг эзэмшүүлэх, шүд угаахын ач холбогдлыг олон нийтэд таниулан сурталчилсны үр дүнд хүүхдүүдийн шүдний өвчлөлийг бууруулах, ард иргэдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгоход оршино.

Нэг. Ерөнхий зохион байгуулалт

1.Тэмцээн 6 минутын сүлд дуутай, тэмцээний лого тэмдэгтэй байна.

2.Уг тэмцээн нь 1 шаттай явагдах ба 2025 оны 10 дугаар сарын 31-ны өдөр зохион байгуулагдана.

3.Аймгийн төрийн болон хувийн өмчийн Ерөнхий боловсролын сургуулийн 4-7-р ангийн /9-12 насны/ сурагчдыг уг тэмцээнд хамруулна.

4.Тухайн насны сурагчдын тооноос хамааран сургууль бүрээс тус бүр 8-н хүүхдийн бүрэлдэхүүнтэй нийт 25 баг тэмцээнд оролцоно. Үүнд:

- Хэрлэн сумын 1-р сургуулиас 4 баг
- Хэрлэн сумын 5-р сургуулиас 3 баг
- Хэрлэн сумын 12-р сургуулиас 3 баг
- Хэрлэн сумын 11-р сургуулиас 2 баг

ХЭРЛЭН СУМ, БАЯНТҮМЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 6-8 ДУГААР
АНГИЙН СУРАГЧДАД ШҮДНИЙ ЦООРЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ Ү
ЗЛЭГ ХИЙХ ХУВААРЬ

2025-9-23, 24



№	Сургуулийн нэр	6-8-р ангийн хүүхдийн тоо	Өглөө эсвэл орой ордог	Сургуулийн эмчийн нэр, утас
1	1-р сургууль	6-р анги - 7-р анги - 8-р анги -		9/24-ний 13 цагт
2	5-р сургууль	6-р анги - 7-р анги - 8-р анги -		9/24-ний 13 цагт
3	12-р сургууль	6-р анги - 7-р анги - 8-р анги -		9/23-ны 13 цагт
4	11-р сургууль	6-р анги - 7-р анги - 8-р анги -		9/23-ны 10 цагт
5	8-р сургууль	6-р анги - 7-р анги - 8-р анги -		9/23-ны 13 цагт
6	2-р сургууль	6-р анги - 7-р анги - 8-р анги -		9/23-ны 9 цагт
7	Шинэ хөгжил	6-р анги - 7-р анги - 8-р анги -		9/23-ны 13 цагт
8	Хан - уул	6-р анги - 7-р анги - 8-р анги -		9/23-ны 9 цагт
9	Долоодой	6-р анги - 7-р анги - 8-р анги -		9/23-ны 11 цагт
10	Флювер	6-р анги - 7-р анги - 8-р анги -		9/23-ны 11 цагт
11	Баянтүмэн сум	6-р анги - 7-р анги - 8-р анги -		9/24-ний 9 цагт



**Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээний
Удирдамж
/Зураг№-3/**

**Шүдний цоорлоос сэргийлэх үзлэгийн
хуваарь
/Зураг№-4/**

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрчимжүүлэх, томуу, томуу төст болон амьсгалын замын бусад халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулах, шинж тэмдгийн тандалт хэрхэн үр дүнтэй хийх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, томуу болон бусад халдварт өвчний харуулан тандалтыг хийх, дархлаажуулалтад хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ЭМГ-ын дэргэдэх Нийгмийн Эрүүл мэндийн төв, аймгийн Боловсролын газрын даргын хамтарсан удирдамжийн хүрээнд 2025 оны 08 дугаар сарын 26-31-ний өдрүүдэд Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд дэмжлэгт хяналтыг зохион байгууллаа.